



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 16 өдөр

Дугаар А/131

Ховд

Бүх нийтийн урлаг соёлын арга хэмжээ явуулах
үйл ажиллагааг түр хугацаагаар хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын “в”, 29.1.6-ын “а”, “л” заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалт, аймгийн Шуурхай штабын хуралдааны 2020 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх эрсдлийг бууруулах зорилгоор 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн бүх нийтийг хамарсан хурал, зөвлөгөөн, урлаг соёлын арга хэмжээний үйл ажиллагааг түр хугацаагаар хориглосугай.

2.Захирамжийг олон нийтэд мэдээлж, сурталчлан хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар, /Э.Даваасүрэн/, Мэргэжлийн хяналтын газар /П.Эрдэнэчулуун/, хяналт тавьж ажиллахыг Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газрын дарга, аймгийн Онцгой комиссын орлогч дэд хурандаа /Б.Алтанбадралт/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ